



**ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН
АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 01-р сарын 11-ны өдөр

Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 удаа хуралдаж хараат бус гишүүний хувьд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон. Үүнд:

1. “Банкны Чанаргүй активын дотоод үнэлгээ”-ний талаар хэлэлцэж тус үнэлгээг холбогдох журмын дагуу Монголбанканд 2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгох;

2. Зээлийн бодлогод дараах өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх. Үүнд:

– Зээлийн бодлогын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь заалтыг “Аливаа банк, санхүүгийн байгууллагад чанаргүй зээлийн үлдэгдэлтэй бол зээл олгохыг хориглоно” гэж өөрчлөн найруулах;

– Зээлийн бодлогын 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг “Банк нь Зээлийн гэрээний хугацаанд эргэн төлөгдөөгүй зээл, түүний хүү болон авлага, бусад төлбөрт тооцон зээлдэгчийн барьцаа хөрөнгө болон бусад хөрөнгийг гэрээ, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр авч үүргийн гүйцэтгэлийг хангуулж болно. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Зээлдэгчээс Банкны эзэмшил, өмчлөлд шилжүүлэх хөрөнгө нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй хэмжээнд байх тохиолдолд Зээлийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, биелэлтийг улирал тутам ТУЗ-д танилцуулна.” гэж өөрчлөх;

– Зээлийн бодлогын 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг “Анхаарал татсан, чанаргүй зээлийг төлүүлэх арга хэмжээний хүрээнд Зээлдэгчээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрөөс Зээлдэгчийг хөнгөлөх, чөлөөлөх тохиолдолд нийт дүн нь Банкны тухайн жилийн нийт хүүгийн орлогын 1 хувиас хэтрэхгүй хэмжээнд байх тохиолдолд Зээлийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, биелэлтийг улирал тутам ТУЗ-д танилцуулна.” гэж өөрчлөх;

– Зээлийн бодлогын 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалтад “Энэ бодлогын 14.3 болон 14.4 дэх хэсэгт заасан хязгаараас хэтэрсэн зээлийн өр төлбөрт тооцож хөрөнгө шилжүүлэн авах болон зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлнэ.” гэж нэмэх;

– Зээлийн бодлогын 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалтад “Банкны холбогдох этгээдээс зээлийн өр төлбөрт тооцож хөрөнгө шилжүүлэн авах болон зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг ТУЗ-ийн хараат бус гишүүний 2/3-аас доошгүй хувийн оролцоотойгоор ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлнэ.” гэж нэмэх;

– Зээлийн бодлогын 14 дүгээр зүйлийн 14.5-дахь заалтыг 14.7 дугаар заалт болгох;

3. Дотоод Аудитын газрын Мэдээлэл технологийн аудитын албаны захирал Б.Одгариг-ийг өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн 2023 оны 12 сарын 01-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэж, түүний хариуцаж байсан эд хөрөнгө, ажлыг хүлээн авахтай холбоотой ажлыг зохион байгуулж ажиллахыг Дотоод аудитын газрын захирал Х.Баттулгад үүрэг болгох;

4. Дотоод Аудитын газрын Мэдээлэл технологийн аудитын албаны захирлаар П.Алтанбагана-ыг 2023 оны 12 сарын 04-ний өдрөөс эхлэн томилох;


5. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Г.Цогтгэрэлийн хүсэлт, Монголбанкнаас ирсэн зөвшөөрлийн албан бичгийг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг томилох, Хувьцаа эзэмшигч П.Раднаабазарын хүсэлт зэрэг асуудлыг тус тус хэлэлцүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 12:00 цагт зарлан хуралдуулах;

6. Дотоод аудитын газрын Ерөнхий аудитын албаны аудитор Д.Жаргалмааг өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр дуусгавар болгон аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх;

7. Тус хурлаас гарсан тогтоол, тэмдэглэлийг холбогдох журмын дагуу хугацаанд нь Монголбанканд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /С.Сайнжаргал/-д үүрэг болгох.

ТУЗ-ын хурлаар дээрх асуудлуудыг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргахад ТУЗ-ын хараат бус гишүүний хувьд саналын зөрүүтэй зүйл байгаагүй болно. Банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын багийн ил тод байдал, шийдвэр гаргалт нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байсан бөгөөд ТУЗ-аас гаргасан гаргасан шийдвэр, тогтоолууд нь банкны харилцагчид, хадгаламж эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөргүй байсан болно.

Тайлан бичсэн:
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Б.Оюунцацрал